

**Монгол хуврагын амьдрал, (XIX зууны сүүлч
XX зууны эхний хагас)**

Ж.Болдбаатар

Монгол улсын их сургууль, Түүхийн судалгааны хүрээлэн

Өгүүллийн товч утга: XIX зууны сүүлч XX зууны эхэн үеийн монгол хувраг буюу монгол ламын амьдралыг бүхэлд нь зураглан харуулахыг оролдсон болой. Өмнөх тогтолцоонд лам нарыг бүхэлд нь сөрөг талаас нь бичиж байсныг түүхийн шинжлэх ухааны шинэ хандлагаар авч үзэж, лам нар тухайн цагийн нийгмийн гол гол үүрэг, хариуцлагыг хүлээж, тэр цагтаа үлгэр жишээч амьдралын хэв маягийг үзүүлж байсныг энэхүү өгүүлэлд шинжлэн үзсэн юм.

Түлхүүр үг: Лам, хувраг, банди, гэвш, гавьж, аграмба, дом, маарамба, зурхай, дацан, мяндаг, зэд, пог, цав, доньд доглох, буян, нүгэл, тэвэг, банди зодоон.

Өмнөх тогтолцоонд “Шашин бол ард түмнийг мунхруулагч хар тамхи” хэмээх марксист үзэл, шашингүйн үзэл (атеизм) газар авч, сүм хийд, лам нарын асуудлыг аль эрт 1930-аад оны сүүлчээр эцэслэн шийдвэрлэсэн гэж үзэж, лам хуврагийг бузар булай бүхний үүр уурхай байсан мэтээр сурталчилж иржээ. Гэсэн хэдий ч ахмад үеийн их зонхи багш ламтай байж, бурханд сүсэглэн, дотроо залбирсаар байсан билээ.

Үнэндээ ч XIX зууны сүүлч XX зууны эх гэхэд монголчуудын дотор бурхны шашныг шүтэн бишрэх явдал туйлдаа хүрч, зарим сөрөг үр дагаварыг өөртөө агуулж байсан гэж хэлж болох боловч, тэр цагт төлөвшсөн “**Монгол лам**” буюу “**Монгол хувраг**” хэмээх нийгмийн давхраа сүсэгтэн олныхоо өмнө “Зовох нь бусдын хүчин бус өөрөө муу үйлдсэнийх, жаргах нь бас бусын хүчин бус өөрөө буян үйлдсэнийх” гэж номлон, буян, нүглийг дэнсэлж, нийгмийн гол, гол үүрэг, хариуцлагыг хүлээж, тухайн үеийн үлгэр жишээч амьдралын хэв маягийг үзүүлж байсан гэж хэлж болохоор байна.

Монгол лам:

- Эх хүн хүндрэлгүй амаржихад туслана,
- Хүүхэд төрөхөд монгол, төвд, санскрит утга төгөлдөр нэр хайрлана,
- Үрийн хүслэн тэгшрээгүй гэр бүлд үрийн заяа хүсч залбирна,
- Хүүхэд өвдөхөд эмчилнэ, ад зэтгэр шүгэлсэн гэж үзвэл тарни, номын хүчээр зайлуулна,
- Хүүхдийн даахь үргээх ёслол найранд хүндтэй суудалд залран, сайныг ерөөнө,
- Банди нарыг өөртөө шавьлуулан, эрдэм номд амлуулахдаа ариун винайн ёс буюу дэг журамтай, шагшаабадтай, ёс тахимдуу байдалд сургана,
- Амьдралын аливаа асуудалд нягт нямбай, арвич хямгач хандах ухаан суулгаж, өдөр тутмын амьдралын зохистой хэрэглээг төлөвшүүлнэ,
- Эр, эм болж ёслох, хуримлахад мутрын болон номын адис хүртээж, амьдралын замыг ариутгана,
- Амьдралд тохиолдох аливаа зовлон, жаргалыг мэдэрч, эргэлзээтэй бүхнийг тайлах мэргэ төлгө буулгана,
- Хадан гэртээ ойртох цагт гэрээс захиасыг нь сонсож, өвдөж тарчилахыг нь нимгэлэхийг хичээнэ,
- Хан хорвоогоос халихад нь ерөөл уншиж, сайн төрөл олох, сүнсийг нь аврахад туслана,
- Номын хүч хаялгаар хүнд итгэл сүсгийг үүсгэж, дотоод сэтгэлийн ариусгал, гэгээрэл, амар амгаланг ханган, хүмүүн хоорондын харилцааг ээвэргүү зөөлөн илүү ёс суртахуунлаг болгох үүрэг хүлээнэ. Үүний зэрэгцээ лам хүн эхнэр авахыг хориглох, нийгмийн бурангуй явдал хүчтэй байсан нөхцөлд дэндүү хүлцэнгүй байдлыг номлох зэрэг сөрөг тал үүсгэж байсныг ч үгүйсгэх аргагүй юм.

I. МОНГОЛЫН ТҮҮХИЙН ДУНДАД ҮЕИЙН АСУУДАЛ

XIX зууны сүүлч XX зууны эхээр Монгол оронд 740 орчим сүм хийд (Жалгын жижиг дуганыг оруулбал 1100 гаруй Ж.Б) ажиллаж, 110 гаруй мянган шавьлан сууж байсан байна. Ийнхүү лам нар монголын нийгмийн бүтцэд томоохон байр суурь эзэлж, ашиг сонирхол, үзэл бодол, улс төрийн үнэлэмжээрээ тун өвөрмөц байдалтай нийгмийн томоохон үүлгийг бүрдүүлж байв. Энэхүү бүлгийг нас, эрдмийн төлөвшлөөр нь, түүнчлэн нийгэмд ээлж буй байр суурь, ахуй байдлаар нь ангилж болно.

Эхний ангиллаар буюу нас, эрдмийн төлөвшлөөр нь авч үзвэл эцэг, эхчүүд наад зах нь нэг хүүхдээ лам болгож, урьд хойтын нүгэл, буянаа даатгаж, төрсөн үрээрээ толгойгоотгүшүүлэх эрмэлзлэлтэй байв. Ийм учраас эцэг, эхчүүд 6-7 наснаас нь хүүгээ төрөл садны буюу нутгийн лам, эсвэл өөрсдийн багш, шавийн барилдлагатай ламтанд хадаг бариулж шавь оруулна. Ингэж шавилсан хөвгүүдийг **банди** хэмээнэ. Тэрхүү банди багштайга хамт нэг гэгэрт амьдарч, төвд цагаан толгой заалгаж эхлэхийн хамт гэр орны ажил хийж сурна. Эхний 3-4 жилийн дотор төвд бичиг, хурлын уншлагатай болж, итгэл, ерөөл цээжилнэ. Цочин дуганын хурлын тогтмол уншлага болох “хангал”, “Чойжид” хэмээх уншлагын ном тогтооно. Багш лам шавиа ганцаарчилан сургах зарчим барьж сургана, лам хувраг хүний сахил санваарт үнэнч байхаа тангараглаж, хурал номын ажиллагаанд оролцож эхлэнэ. Энэ үедээ төвдөөр чөлөөтэй уншдаг болж, хурлын уншлагын нэлээд олон ном үзэж тогтоон, шашны бага сургуулийн боловсролтой болно.

Энэ үедээ бага, залуу лам нар сахил хүртэнэ. (1) 1921 оны хувьсгалын босгон дээр Монгол оноор аялсан Мажар улсын иргэн Иозеф Гелетагийн тэмдэглэлийг хожим “Өргөө дахь цус хядлага” хэмээх ном болгон бичсэн Ладислаус Формат лам нарт хэрхэн сахил хүртэж байсан тухай:

“Лам болох хүнийг хүүхэд үеэс нь хийдэд суулгаж, жинхэнэ сүсэгтэн лам болтлоо олон жил зурч ажиллана. Тэдгээрийг шалгаж хэргэм зэрэг олгохдоо хийдэд лам нарын хурлаар шийдэх бөгөөд залуу хүмүүсийг бөөнөөр оруулж зогсоогоод ахмад лам нар мэдлэгийг нь шалгана. Энэ шалгалтанд суугч лам нарт хандаж, хийдийн тэргүүн лам дараах маяар асуулт тавина.

-Буханы шавь нар аа, та нар залуу хүүд ... зиндаа олгохыг болгооно уу? гэнэ. Хэрэв сайн үнэлгээ авбал тухайн хүн ламын эгнээнд орох ба эс зөвшөөрөгдвөл дараагийн жил дахин шалгалтанд орно. Азтай банди нар баяр ёслолыг хамтдаа гүйцэтгэнэ. Хийдийн тэргүүн лам тэрхүү залууст сахил хүртээхдээ тэднийг дараах байдлаар нэгэн дуугаар хэлүүлнэ.

- -Биамьтны амийг хэзээ ч хорлохгүйгээ андгайлж байна.
- Бикүний юмыг хэзээ ч авахгүйгээ андгайлж байна.
- Биалив садар самууныг тэвчин үл үйлдэнэ.
- Бикээээ ч худал хэлэх, гүжир гүтгэлэгийг үйлдэхгүй.
- Бикээээ ч согтууруулах ундааг хэрэглэхгүй.
- Бикээээ ч хориотой өдөр хоол идэхгүй.
- Би зугаа цэнгэлийн үүднээс дуу дуулж бүжиг хийх, хөгжим сонсож, жүжиг үзэхгүй гэдгийг андгайлж байна.
- Биүнэртэй ус, саван хэрэглэх, мөн үнэт чулуу зүүхгүйгээ андгайлж байна.
- Бихэдийгээр дунд нь амьдарч байвч алт мөнгө цуглуулахгүйгээ андгайлж байна гэнэ.

Залуу лам нарын энэхүү нэгэн дуугаар нүргэлүүлэн андгайлах нь сүмийн оройгоор сүртэй цууайтан сонсогдоно” (2, 135-136) хэмээн бичсэн байна.

Шашны сургууль, ялангуяа бага сургуульд хичээл номондоо омтгойтсон банди нарыг багш лам цохон дээр нь дээр юм уу, үсний эргүүлгийн хоёр цэгт няслах, бас алган дээр нь шугамаар цохино. Учир нь эдгээр цэгүүдэд сэрэл мэдрэмжийн гол судас байдаг тул түүнийг сэргээж өгөх зорилготой ийм үйлдэл хийнэ. Иймээс шоглох нь хүртэл цаанаа учир начингай байжээ. Мэдээж, тухайн ламтны ааш араншингаас болж, хэтрүүлэн зодох явдал гарч байсан л байх.

Шашны анхан шатны боловсролтой болсон **15-20 насны лам-банди** нар дотоод ухаан буюу гүн ухааны Дашчойнбүл, Гунгаачойлон, Идгаачойлон хийгээд Жүн дацангуудад хуваарилагдан, шашны дунд сургуулийн боловсрол олохоор суралцдаг. Эдгээр дацангуудад суралцагчид нь доод, дунд, ахлах зиндаа хэмээх гурван ангид хуваагдан бурханы ном эрдэмд шамдана. Үүнд:

1. Доод ангид таван жил суралцаж, учир шалтгааны ухаан, сэтгэхүйн зүйг голлон судлахаас гадна төвд хэл, буддизмын товч түүхийг үзнэ.

2. Парамита буюу парчин (билэг пирамид) судалдаг дунд ангид таван жил суралцаж, хутагт билгийн цаад хязгаарт хүрэх ёс, тухайлж хэлбэл бурхан болох ёсыг голлон судлахын зэрэгцээгээр абидхарма, сэтгэхүйн зүй, винайн ёсыг тус тус судлана.

3. Ахлах ангид дөрвөн жил суралцаж, дундат үзэлд орох ёсыг голлон судлахаас гадна дунд ангид үзсэн абидхармын ёс болон винайн сургаалыг улам гүнзгийрүүлэн судлана. (3,308) Чингэхдээ нэг анги буюу зиндаанд 10-20 банди хамрагдах бөгөөд өглөө, өдөр, орой хичээллэж, хэд хэдэн багш төрөл бүрийн хичээл заана. Банди нар жил бүр шалгалт өгч анги дэвшинэ. Дунд шатанд урьдын адил цээжлэх сургалт зонхилох боловч, цээжилснээ бясалгаж эхэлнэ. Бас зиндаа зиндаагаараа хоорондоо ном хаялцах (дагсалцах) юм уу, эсвэл зиндаа дотроо ном хаялцаж ухаанаа задлана. Дагсалцах явцад эргэлзэх, тээнэгэлзэх, шүүмжлэх явдал олонтаа тохиолдоно. Энэ нь амьдралын ухаарлыг хөглөж, чөлөөт сэтгэлгээ рүү аяндаа хөтөлнө. Ийнхүү бурхны номонд цагааширч, дунд сургууль төгсөхдөө дом тавина. Энэ нь хэрэг дээрээ төгсөлтийн шалгалт өгч буй хэрэг юм. Их төлөв цэцэг ногоо дэлгэрч эхэлж буй зуны эхэн сард дом тавина. (4) Шашны дунд сургууль дүүргэх үедээ банди нарын нас 25-30 хооронд байна. Ихэнхи лам банди нар домын дамжаа дүүргээд, гэвш болно. Цаашид ахих дөхөхийг бодохгүй зарим нь зөвхөн хурлын лам болж, сүм хийддээ эргэл мөргөл үйлдэн насыг бардаг байсан аж.

1930-аад онд сүм хийдийн татвар нэмэгдсэн үед чинээлэг хүмүүс жас жавд чамгүй хөрөнгө өгч номтой банди нарын нөмөр нөөлөгт хүүгээ багтаан, шашны бага сургууль дүүргэж дуусмагц дом тавиулж байсан аж. 2004 онд Булган аймгийн Бугат сумын харъяат 80 настай Д.Гэсэржав гуай: “Намайг арван нас хүрэхтэй үгүйтэй байхад эцэг, эх маань 20 гаруй том ах нартай нийлүүлэн домын дамжаа бариулж байсан” (5,150) хэмээн дурсан ярьсан юм.

Банди, залуу лам нар хичээлийнхээ чөлөө заванд багшийнхаа гэрийн ажлыг амжуулахын хамт янз бүрээр тоглож наадна. Лам банди нарын дотор ихэд дэлгэрсэн тоглоом бол **барилдаж, хүчээ үзэх, тэвэг өшиглөх, бие биедээ өдсөн үг хэлж, хөөцөлдөн хөгжилдөх, банди зодоонд суралцаж, талцаж зодолдох, хушга харваж наадах, цагаан тэмээцэх** зэрэг юм.

Хар багаасаа барилдаж ноцолдох нь монгол эрчүүдийн төрөлх чанар, ёс мэт үйлдэл бөгөөд лам нар ч тэр л уламжлалын дагуу явж, тэдний дундаас алдар цуутай бөх олон төрж байсан билээ. Түшээт хан аймгийн Дайчин вангийн хошууны бөхийн даамал Эрэн чайтан хэмээх хүрээний банди нар, хүүхдүүдийг чихэр, боовны урамшуулалтай барилдуулж явдаг “бөхөөр өвчилсөн” нэгэн байжээ. Багш лам нар, айлын авгай нар “Гайтай муу Эрэн пайтангаас болж, хүүхдийн хувцас тэсэхгүй юм” гэж үглэдэг байсан аж.

Лам банди нарын дотор хамгийн өргөн дэлгэрсэн тоглоом бол тэвэг өшиглөх юм. Хонины сэгсүүрэгнээс дугуй хайчилж аваад дээр үеийн гуравт, тавтын мөнгөний хэмжээний давтсан дугуй тугалан дээр бэхлэж тогтоосоныг тэвэг гэнэ. Түүнийг өшиглөн хөөрүүлж, дахин дахин давтана. Эхлээд 3,5,7,9 гэсэн сондгой тоогоор тоолж өшиглөхийг нэг тоо гүйцээх хэмээнэ. Дараа нь дан тамгыг өвөр талаараа 7-10 удаа өшиглөнө. Давхар тамгыг араараа мөн тооны хэмжээнд өшиглөж гүйцэтгэнэ. Хэн цэвэр, ёсоор нь өшиглөж бүгдийг түрүүнд гүйцээсэн нь хождог.

Бас хоёр, хоёроороо баг болж дамжуулж өшиглөж байжээ. Үүнийг хүн бүр амархан гүйцэтгэж чадахгүй, бүр онцгой гаршсан, мэргэшсэн чадварлаг хэсэг нь мөрий тавьж тоглодог байсан аж.

I. МОНГОЛЫН ТҮҮХИЙН ДУНДАД ҮЕИЙН АСУУДАЛ

Лам нарын “банди зодоон” нь спортын нэг өвөрмөц төрөл болж байжээ. Банди зодооныг том нь багадаа зааж өгнө. Банди зодоонд гаршсан залуу лам банди нарыг бүснээс нь өргөж, булчин шөрмөсийн чанга эсэхийг үзээд бие султай эсэхийг шалгаж, багтаа авдаг байжээ. Залуу лам, банди нар “Хоёр үзэхгүй, хонзон санахгүй” гэж тангараглаад хоорондоо юм уу, багаар зодолдож, ур чадвараа сорьдог байсан гэнэ. Гар, хөлөөрөө хослуулан зодолдоно. Гэхдээ хүний амь насанд халтай эмзэг газар луу өшиглөх, цохихыг цээрлэнэ. Энэ мэт тоглоомууд нь хөдөлгөөн багатай, сууж бясалгадаг лам, банди нарын биеийг чангаруулж, чийрэгжүүлж байсан байна. Бас араас нь очиж, нэг нэгнийхээ нүдийг дарж, “Цавын будаа идэх үү, цавуутай толгой тэврэх үү” гэж асууна. (цавын будаа иднэ гэдэг нь лам болохыг хэлнэ. Цавуутай толгой тэврэнэ гэдэг нь эхнэр авахыг хэлж буй хэрэг). Хариулт хэлсний дараа бие биеэ дооглож, хөөцөлдөж хөгжилдөнө.

Гурав дахь шат нь шашны дээд сургууль болой. Өөрөөр хэлбэл, гаарамбын дамжаанд сурч эхэлнэ. Энэ шатанд 10-20 жил өмнөх үзсэнээ давтах, гүнзгийрүүлэх тайлбар хийх, шинээр зохиол бичих зэргээр их төлөв бие даан судлана. Шашны дээд сургуульд дээд эрэмбийн номлол, буддын шашны ванай хэмээх сахилга бат, зохион байгуулалтын тухай сургаал, гүн ухаан, шашны түүх зэрэгт илүү анхаарна. Эдгээр онол, практикийн асуудлыг нарийсган тулхтай судлаж, түүнийг хэрэгжүүлэх бодит үйлдэлийг аль болохоор эрхэмлэнэ. Чингээд гавьжийн дамжаа барина. Барагцаалбал, гавьжийн дамжаа барьж буй лам 700 гаруй нүүртэй 5 сүмбүм номыг (6,358) ойн тойндoo суулган задлаж сэтгэж, тодорхой сэдвээр ном хаялцах буюу дагсал хаялцаж, ширүүн марган номтой шүнтэй болохоо нутлан харуулж, гавьж хэмээх мяндаг хүртэж байжээ.

Шашны дээд сургууль буюу академид суралцсан лам нарын ихэнх нь 50 эргэм насандаа **гавьж мяндаг** хүртэж байсан байна. Манай нагац өвөө Буджавын Ёндон 1920-иод оны эцсээр Дайчин вангийн хүрээнд гавьжийн дамжаа барьжээ. Ээж маань: “Аа-г (Ах дүү нар нь Ёндон гавьжийг Аа хэмээн авгайлдаг. Ж.Б) гавьжийн дамжаа барихад манайх Вангийн хүрээний ойр ирж бууж, айраг цагаан идээ бэлтгэн, 4-5 тэргээр Вангийн хүрээрүү зөөж байсан. Ах нар ярихдаа Аа маань маш их эрдэмтэй болж, лам нарын асуултыг огт түгэдрэлгүй хариулж байна хэмээн бахдан ярьж байсан” (7) гэж хуучилсан юм. Гавьжийн дамжаа барьж буй лам номын хурим хийхдээ төрөл бүрийн үнэт чулуун хөөрөг гурав, шаазан хөөрөг гураваар тамхилдаг ёстой байсан гэнэ. Ийм учраас гавьжийн дамжаа барихдаа их төлөв биеэ биеэсээ хөөрөг зээлдэн барьж тамхилдаг байжээ. (8)

1930-аад онд сүм хийдээс авах татвар өссөн үед гавьжийн дамжаа барих хүний тоо цэмэгдэж, нэгэн номтой хүний нөмөр нөөлөг дор хэд хэдэн эрдэм номоор гавихгүй хүн дагаж гавьж болж байжээ. Тухайлбал, чинээлэг айл хүүгээ гавьж болгохын тулд сүм хийдэд их хэмжээний өргөл барьц, адуу мал өргөж, номтой шүнтэй хүнийг дагуулан хомрогонд тэрхүү мяндагийг хүртэж байсан аж. Ингэж цугларсан хөрөнгөөр сүм хийдүүд татвараа төлж байсан гэнэ. Эдүгээгийн Булган аймгийн Бугат сумын харъяат, улсын заан Данзансодовын эцэг, эх шаггүй хөрөнгөтэй айл байсан тул ном эрдэмдээ төдий л гавихгүй байсан түүнийг ийм маягаар 1936 онд гавьж болгосны харгайгаар 1937 онд баригдаж, хилс ял эдэлж байжээ. Гавьжийн дамжаа барьж буй ламтан хурал номын зардал, номын хурим хийхэд 6000 хүртэл рублийг зарцуулж байсан тооцоо бий. (9,17)

Гавьжийн дамжаа барьсан лам нараас өдрийн од шиг цөөн санваартан буддийн агийн ном буюу тарнийн ухааныг жүд дацанд элсэн орно. Энэ нь нэг ёсны шашны академи юм. Эл дацанд 10-15 жил суралцаж, гол нь бурхан болох онолыг судлаж үйлдлэг бясалгалыг хийнэ. Хэрэв сайн суралцаж чадвал 60 орчим насндаа аграмбын дамжаа барьж, шашны дээд мяндаг хүртэнэ. **Аграмба мяндаг хүртсэн хүн “Доньд доголдог” байжээ.** Өөрөөр хэлбэл, билгийн чинадад дөхөх буюу хоосон чанарт шилжинэ. Хоосон чанарт шилжсэн жишээнд Алашагийн Дандар Лхарамба (1759-1840), Дайчин вангийн Дандар агримба (1835-1915) нарыг нэрлэж болох юм.

Дандар лхарамбын шавь 50 шахуу насны гавьж:

-Би мөн чиг олон жил ном үзлээ, олон шад ном цээжилжээ. Би “доньд доглосон байх” гэж дотроо боддог байжээ. Нэг өдөр тэр гавьжийн нутгийн хар хүн Дандар лхарамбад бараалхав. Нөгөө гавьж нутгийн хүнтэйгээ уулзах нэрийдлээр багшийндаа оржээ. Багштайгаа болон нутгийнхаа хүнтэй халуун дотно яриа өрнүүлж байгаад:

-Багш аа, “доньд доголно” гэдэг чинь яадаг хэрэг вэ? гэж асуужээ. Багш нь:

-Чамд яаж ойлгуулдаг юм билээ дээ гэхэд нөгөө гавьж дотроо “Ойлгоход хэцүү болгож багш бултах нь дээ” гэж бодов. Тэгтэл Дандар лхарамба:

-Тэр гаансыг аваад өгөөч гэжээ. Шавь нь нутгийнхаа хар хүний гансыг авч өглөө. Дандар лхарамба тооно, өрхний завсараар орж ирсэн нарийн гэрэл дээр нөгөө гаансыг өлгөж орхив. Лхарамбын шавь гавьж дотроо “Ээ, бурхан минь, би энэ насандаа л доньд доглож чадахгүй юм байна. Би нүгэлтэй юм бодож явж” хэмээн эрэгцүүлээд багшийнхаа гэрээс бушуухан гарч явсан гэдэг.

Дайчин вангийн Дандар аграмбаас нэг шавь нь:

-Яаж доньд доголдог юм бэ? гэхэд Дандар аграмба:

-Чамд ойлгуулахад хэцүү л дээ, гэхдээ гээд багана дундуур чөлөөтэй гараа явуулж байжээ. Шавь нь гүйж гараад багана дундуур гараа явуулах санаатай оролдтол таг, яг хийтэл мөргөж, гараа өвтгөхөөс цаашгүй байсан гэдэг. Монголд аграмбын мяндаг хүртсэн хүн 40-50-ийн хооронд байсан (6,358) хэмээн судлаачид бичсэн байна. Эдгээр аграмба мяндагтан, доньд доголсон лам нар билгийн чинад дөхсөн ч билгийн чинад хараахан хүрээгүй санваартнууд юм. Хэрэв хэн нэгэн хүн бурхны номын оргилд хүрэх юм бол бурхан шиг төгс боловсорсон цэцэн мэргэн гаргууд ухаантай болох ёстой гэж бурхны шашин номлодог.

Түүнчлэн лам нарын нийгэмд эзэлж байсан байр суурь, хөрөнгө чинээ, амьдрал ахуйн нөхцлөөр нь дээд, дунд, эгэл лам нар гэж хувааж болох юм. 1925 оны V сард МАХН-ын Төв Хорооноос нийтлүүлсэн “МАХН-ын шашин шүтлэгийн тухай гол бодлого ба товч тогтоол” товхимолд “...Лам нар үлэмжхэн тоонд хүрсэн бөгөөд тэдгээрийн байдал төлөв, зорилго суртал харилцан адилгүй, монголын олон ард, язгууртан зэргийн байдлыг дагалдан салбарласан байх тул лам нар гэж нэгэн этгээдэд үзэж болохгүй, лам нар бол дотроо дээд, дунд, дорд хэмээх гурван анги ялгаварлагдах ба дээд лам нар нь хутагт, хувилгаад, тойд, шавран, жич дацан хийдийн ба урьд шавийн албан хаагч лам нар болон бараа бологчид цөм багтана. Дунд лам нар хэмээсний дотор энгийн гавьж, гэвш зэрэг эрдэмд хүрэлцсэн лам нар ... дорд хэмээсний дотор бага насны хувраг банди нар бөгөөд дацангуудын тахилч, дуганч зам нар ба ихээхэн лам нарын зарцууд бөгөөд угаасаа үгээгүй хоосон хүмүүс болох тул гавьж, гэвш болохын зардал сүйтгэлийг бүрдүүлж чадахгүй хүмүүс байна” (10,45-47) гэж тэмдэглэжээ.

Дээд лам нарт VIII Богд Жибзундамба хутагт, тамгатай, тамгагүй хутагт хувилгаад, томоохон сүм хийдийн хамба, дэд хамба, цорж, XX зууны эхээр Монгол оронд зах зээлд татагдсан орсоноор шинээр үүсэн төрсөн лам баячууд орж байжээ.

Дээд лам нарын хамгийн том нь “оройн дээд”, “амьд бурхан” хэмээн шүтэгдэж байсан VIII Богд Жибзундамба юм. XX зууны эх гэхэд тэрбээр 90 гаруй мянган шавьтай, 100 шахам мянган толгой малтай байжээ. (11,575) Дараа нь тамгатай хутагт, хутагт хувилгааднууд орж байсан.

Манж Чин улсын хуулинд хутагтад тамга олгох шавь нарын тоог 500, 700, 800 гэх мэтээр харилцан адилгүй зааж байсан нь тухайн цаг үетэйгээ холбоотой хэлбэлзэж байжээ. Харин сүүлд нь хутагтад тамга олгох шавь нарын тоо, газар нутгийн нөхцлийг 800 илүү шавьтай, харъяат хошуунаас 500 газар хол нутагтай бол тамга өгч шавь нарыг захируулахаар заасан байна. 1921 оны хувьсгалын өмнө тамгатай хутагт 13, тамгагүй хутагт хувилгаан 50 орчим байжээ. (11,183) Тамгатай хутагт нар өөрийн гэсэн хүрээ хийдтэй, тодорхой цэс бүхий газар нутагтай, шавийн захиргаа, жас аж ахуйтай, томоохон нь хошуудтай өрсөлдөхүйц цар хэмжээтэй байсан байна. Тамгагүй хутагт хувилгаад ч зохих хэмжээний мал хөрөнгөтэй, өргөл барьц олбор бүхий сүсэгтэн олны өргөмжлөн

I. МОНГОЛЫН ТҮҮХИЙН ДУНДАД ҮЕИЙН АСУУДАЛ

хүндлэгдсэн чинээлэг санваартнуудын тоонд зүй ёсоор орж байжээ. 1924 оны байдлаар Монголын хүн амын дөрөвний нэг буюу 150000 хүн хутагт харт харъяалагдаж, хутагт хувилгаадад хүн амын орлогын тавны нэг нь орж байжээ. (12,161)

Дээд лам нарын тоонд хутагт, хувилгаадын дараа томоохон хүрээ хийдийн удирдах албан тушаалтнууд болох хамба, дэд хамба, цорж, да лам зэрэг орно. 1909 оны тоо бүртгэлийн мэдээгээр Их Хүрээнд гэхэд хамба, дэд хамба, цорж, да лам, унзад, гэсгүй, нярав зэрэг дээд зиндааны лам 1000 шахам байжээ. Түүнээс гадна, тус хүрээнд 800-1000 шахам гавьж, аграмба мяндагтай лам нар сууж байсан аж. Тэд албан тушаал, хэргэм зэрэг, эрдмийн цол, мяндагаараа бусад лам нараас нийгэмд илүү давуу байр суурь эзэлж, хангамж, орлого сайтай амьдарч байв. Зарим нэг жишээ дурдахад, Олноо өргөгдсөн Монгол улс байгуулагдмагц Богд хааны зарлигаар Их Хүрээний хамба ба дэд хамбад хутагт цол олгож, хамба ламд жилийн 500 лан мөнгөний цалин, шар жуузын хамт, дэд хамбад жилийн 300 лан мөнгөний цалин, ногоон жуузны хамт олгохоор тогтоожээ. Түүнчлэн дээд зиндааны зарим лам нарт хар ноёдын нэг адил цол хэргэм олгожээ. Тухайлбал, 1914 оны хавар лам Бадамдорж, Цэрэнчимэд, Дашдэндэв нарт чин ван, лам Дашжавт жүн ван цол, лам Лувсанбалдан, Гомбосүрэн, Пунцагдорж, Цэрэндэв нарт гүн цол олгожээ. (13) Тэд авсан цол хэргэмийнхээ дагуу тодорхой тооны хамжлага захирч, цалин пүнлүү хүртэх болсон байна.

“Зарлигаар тогтоосон Монгол улсын хууль зүйлийн бичиг”-т дээд лам нарын хувцас, унаа, жолоо, гэр хашаа, ёслолын үед суух суудал, жагсах дэс дараа зэргийг нарийвчлан тогтоож өгсөн нь тэдний статусыг илэрхийлэх үндсэн гол үзүүлэлт юм. Дурьдан буй хуулийн “Олон хамба, хутагт номун хан, бандид цоржийн зэрэг лам нарын хэрэглэвээс зохих дээл дэвсгэр, сүйх тэрэг, гэр хашааны дүрэм”-д: “Нийслэл хүрээний хамба номун хан, ёнзон хамба, дэд хамба, олон хутагт номун хан, бандид цорж хувилгаан лам нарын хэрэглэвээс зохих ёст дээл болвоос цөм шар өнгийн магнаг хүрэм болвоос шар өнгө, бүс хэрэгсэх үгүй, дэвсгэр болвоос хамбын ямба, долоон давхцлага, магнаг олбог, түшлэг, цоржийн ямба таван давхцлага, цэн бун олбог, түшлэг, хувилгааны ямба гурван давхцлага, дэнбун олбог түшлэг, жинхэнэ Да ламын ямба гурав дор хэрэглэх үе улиран хэрэгсэх жич гавъяа зүтгэлийг үзэж хэрэглүүлэх нь тус тус ялгавар буй” (14,144-145) хэмээжээ.

Хууль ёсоор олон хамба, хутагт нарын гэр нь улаан хөмрөгтэй, улаан өнгийн нуруу бүхий цагаан хашаатай, дотроо гурван өрөө, их хаалгандаа асартай, хаалга, багана нь цулуун улаан өнгө бүхий, гуулин гархитай байжээ. Харин да лам нар цөм дурай модон хашаа, улаан хашаа, улаан өнгийн нуруу дотор хоёр өрөө, их хаалга нь бага асартай, хаалганы өнгө улаан, тугалган гархитай байсан аж. Цорж, хувилгаан лам нар дүрст модон хашаа, харавтар улаан өнгийн нуруу, дотроо нэгэн өрөө, их хаалгандаа ерийн асартай, хаалга улаан бусад нь харавтар улаан өнгөтэй, төмөр гархитай байсан байна.

Тэр бүр мяндаг, тушаалгүй ч баян чинээлэг лам нарыг дээд хэсэгт багтаан үзэж болох юм. XX зууны эхэнд 20-иос дээш мянган малтай 30 шахам баячуул төрсөний дотор Дайчин вангийн Сүрэн гавьж, Их Хүрээний Бүтэмж гэлэн зэрэг хэд, хэдэн лам хувраг байжээ. Сүрэн гавжийн мал сүргийг Дайчин вангийн хошуу даяар маллаж жинд явахдаа шарыг зуу, зуугаар ижилсүүлэн хөллөж, зарим жил хошууныхаа алба татварыг бүхэлд нь ганцаараа дааж, урьдчилан төлж байсан гэдэг. (15.137,145) Бурханы шашны ном ёсоор шунал тачаалыг тэвчих ёстой боловч, хүн л юм болохоор лам нарын дотор баяжих тансаг амьдрах эрмэлзэл, хүчтэй болж байжээ. Академич И.М.Майский ийм нэгэн тохиолдлын тухай өгүүлэхдээ: "... Арьяаболын сүмд (16) ороод гарахдаа Гандангийн хойт ногоон дэнж дээр зусланд гарсан лам нарын олон гэрийн хажуугаар цуг яваа хүмүүстэйгээ явж байтал нэгэн нас тогтсон намбалаг лам ялдамхан мэндэлж биднийг гэртээ цайнд урив. Бид түүний зуны гэрт ороод, Арьяабол бурханы хүчирхэг дүрийг хараад төрсөн сэтгэгдэл замхраагүй байсан болохоор гэрийн эзнээс буддийн аврагчийн тухай, түүний хачин гайхамшигтай баримлын тухай, монголын ард түмний шашин шүтлэгийг тухай асууж

гарлаа. Гэтэл миний яриа, асуулт хаа байхав. Сайхь лам маань намайг сонсохыг ч хүссэнгүй. Оросын ердийн рубль л түүний сонирхолыг татаад байжээ. Тэр маань оросын цаасан мөнгө ямар баталгаатай юм, ханш нь хэдийд өсөх юм бол гэдгийг л мэдэх гээд байв. Сонирхож байсан сэдэв рүүгээ би яриаг нь гулсуулах гэж оролдсон чинь бүтэх янз алга. Лам маань зөвхөн рублийн тухай, зээлийн билетийн тухай, алтан зоосны тухай, оросын ч хятадын ч мөнгөн дэвсгэрийн давуу талын тухай яриад байдаг. Ингэж ярихдаа түүний нүдэнд онгод асах мэт, нүсэр том бие нь сэтгэлийн дотоод догдлолоосоо болоод чичирхийлэх мэт болж байв. Би ламынд бүтэн цаг суусан боловч Арьяаболын тухай юу ч олж сонсонгүй. Харин сайхь лам зэгсэн сайн санхүүч, мөнгөний гүйлгээний нууцын учир начинрыг сүрхий гадарладаг нэгэн байна гэдгийг би ямар ч эргэлзээгүй гэрчилж чадах байна” (6,362) гэжээ.

Зарим сүм хийдийн жасын нярав овсгоо самбаа гарган ажиллаж, мөнгө хүүлэх замаар хийддээ ч, өөртөө ч ашиг орлого оруулж чадаж байжээ. Тэд ийм маягаар ахуйн хувьд лам нарын дээд хэсэгт багтаж байсан байна. Дээр цухас төдий дурьдсан баримтаас үзэхэд, хүрээ хийдүүдийн дээд зиндааны лам хүний ахуй амьдрал ямар янзтай байсан нь нэн тодорхой. Харин өмнөх судлаачид (17,117,119) гавьж, аграмба мяндагтай лам нарыг бараг бүхэлд нь дээд зиндааны лам нарын тоонд оруулж үзэж байсныг эргэж харууштай байна. Учир нь гавьж, аграмба мяндагтай лам оюун билгийнхээ хүчээр хурлын зэд (18), пог (19) ахиухан хүртэж, нийгэмд эзлэх байр суурь илүү байсан болохоос бидний өгүүлсэн дээд зиндаанд багтах албан тушаал, хэргэм зэрэг бүхий лам нараас ахуй амьдралын хувьд үлэмж доогуур байсан байна. Тэдний дотроос харьцангуй билгийн чинад дөхсөн зарим нь шунал тачаалыг умартан, ариун винайн ёсыг сайтар сахиж, эд хөрөнгө, өнгө мөнгөнд үл автаж байжээ. Иймээс тэдний их зонхи нь ахуй байдлын хувьд дунд зиндаанд багтаж байсан аж.

Дунд, доорд буюу эгэл лам нарын их зонхи нь сахил санваар хүртэж, насан туршдаа хүрээ хийд, хурал ном бараадан амьдарч зэрэг зиндаа, эрдэм номынхоо чадал, нэр хүндийнхээ хирээр олон, цөөн шавьтай болж, бурхны ном бясалгадаг, ариун винай ёсыг эрхэмлэдэг нийгмийн томоохон, өвөрмөц бүлэг юм. Тэдний иргэний амьдралын үндсэн шинж бол хүний ёсыг умартсан гоонь шинж, хувиа борлуулж довоо шарлуулсан ахуй байдал, ариун винайн ёсыг сахих эрмэлзлэл болой.

Дунд, дорд зиндааны лам нар үндсэндээ хурлын зэд, пог, бага сага өргөл барьцаар амьдралаа залгуулж байсан гэж үзэж болно. Харин зэд, погийг хуваарилахдаа дорд лам нараас хамба 5-7, цорж ба ширээт лам нар 5, да лам, ловон нар 3-5, гэсгүй, умзад 3, гавьж, аграмба нар 2-3 дахин илүү “намшиг” (20) хүртэж байжээ. (21,77) Үүнийг ангийн байр сууринаас тайлбарлахаасаа илүү ажил үүргийн хуваарь, ачаалал, хариуцлага, эрдэм билэг, чадал чансааны нь үүднээс тогтоосон гэж үзвэл зохилтой.

Дунд зиндааны лам нарт гэсгүй, умзад, зарим ловон, нярав зэрэг албан тушаалтан, гавьж, аграмба мяндагтан, зарим гэлэн нар орж байжээ. Барагцаагаар тооцвол ийм зиндааны лам нар 1914 оны байдлаар Их Хүрээнд 4000 гаруй байжээ. Тэд дорд лам нарыг бодвол өөрийн гэсэн хашаа, гэр, байшин сууцтай, сольж өмсөх арай чанартай хувцас, хэрэглэлтэй байсан аж. Зарим нь таван ханатай гэртэй, тохилог хашаа байшинтай, торго дурдан хувьцастай байхад их зонхи нь дөрвөн ханатай жижиг гэртэй, даалимба, сатин, жигүүнэн хувцастай байсан байна. Харин гэр бүхий лам нар гэр дээгүүрээ давхар давуу тэлүүр буюу асар маягийн зүйл, арай хожим нь чинээлэг хэсэг нь төмөр дээвэр хэрэглэдэг байжээ. Ийм дунд зиндааны лам нарын тухай Их Хүрээний гавьж, хожим Гандантэгчинлин хийдийн хамба лам болсон С.Гомбожав гуай: “...Гавьж болсны дараа миний амьдрал дээшилсэн юм. Гэвч, бүх гавьж нар чинээлэг хангалуун, тарган цатгалан амьдарч байгаагүй. Үнэнийг хэлэхэд, Их Хүрээний гавьж нарын нэлээд хэсэг нь ядуувтар амьдарч байсан бөгөөд бачуу жижигхэн гэрт сууж, гавжийнхаа дугуй, хурлаас оногддог манз цаваар л болгодог байсан. Гэвч над мэтийн дарживтар гавьж нарын зэрэгцээгээр өндөр тушаалтай, мөнгө хүүлж, худалдаа маймаагаар баяжсан чинээлэг гавьж гуай нар

олон байсан” (22) хэмээн 1950-иад оны сүүлчээр хуучилж байжээ. Энэ бол дунд зиндааны лам нарын ахуй байдлыг ерөнхийд нь өгүүлсэн зураглал юм.

Их Хүрээний лам нарын тал илүү хувь нь дорд зиндааны буюу эгэл лам байсан байна. Тодруулан хэлбэл, 1914 онд Их Хүрээнд 13754 лам байснаас 7687 нь дорд зиндааныхан байж. Тэд Их Хүрээний лам нарын 55,9 хувь болж байсан байна. (21,123)

Эгэл лам нарын их зонхи нь өөрийн гэсэн гэр оронгүй. Их төлөв хөдөө орон нутгаас ном үзэхээр ирсэн хүмүүс байжээ. Иймээс тэд гол төлөв нутаг нутгийнхаа дээд болон дунд зиндааны лам нарыг бараадан, шавь орж, тэдний гэр зуурын ажлыг хөдөлгөнө. Хуралд бүртгэл авч, зэд, погоороо амь зууна. 1906 оноос эхлэн Их Хүрээнд сууж байсан лам Санжаа: “Домын зиндаанаас доошхи дунд лам нар өөрийн гэх оронгүй, танил лам нар юм уу, багшийндаа сууна. Шавь нар нь бид багшийнхаа бүх ажлыг хийхийн хамт ном үзнэ. Бид өглөө хар цайнаас өөр юу ч амсалгүй, хуралд очиж хураад, үдэд л нэг удаа хоолонд хүрдэг явдал олонтаа байсан. Орой бас олдвол боовны хэлтэрхий аягандаа хийж иднэ, үгүй бол хар цайгаа л уугаад унтдагсан” (23) хэмээн дурсан ярьж байжээ. Түүнчлэн 1901 оноос 1923 он хүртэл Их Хүрээний Бандидын аймагт шавьлан сууж байсан Тунсаг: “Би 12 насандаа (1901 он) Их Хүрээний Бандидын аймагт өөрийн их гавьжийнд ирж суусан ба Ламрим дацанд хурдаг байлаа. Манай гэр ойр, Хэрлэнд байсан болохоор гэрээс хоол хүнсний дэмжлэг авч өлсөхгүй амьдарч байсан юм. Харин хол нутгийн ядуу лам нар өлсч, багшийнхаа юмыг ч хулгайлан идэж явсан удаа бий.

Ах дүүгийн дэмжлэггүй хүмүүс зөвхөн зэд, погоор амьдарч үл чадна. Дээр үед даалимбан дээд цагаан сарын гоёл болж байсан ... Ер нь банди нар хувцсаар муу, майжиг гуталтай хувраг олон байсан. Дуганч, манзач нар бол голдуу ядуу хүн байдаг. Ихэнх ядуу лам гэргүй, багшийндаа юм уу, эсвэл 3 - 4 өөрөө нийлж сууна. Банди нарт сард 5-10 удаа цав (хоол) олддог байсан ба өглөө юу ч идэлгүй, хар цай уугаад хуралд очих удаа ч бий. Оройдоо бол боовны булан иднэ. Байхгүй бол цайгаа уугаад унтана” (24) хэмээн ярьж байсан аж.

Дорноговь аймгийн Даланжаргалан сумын малчин Доржням: “Манай энүүхэн зүүнтээх Далантүрүүнд байгаа лам хувраг явсан нэгэн ламбугайнд би хоног төөрүүлэх болдог юм байна. Гэртээ ганцаархнаа амьдардаг тэр гуай хүний мөрөөсөл болсон юм уу эсхүл намайг тоосон ч юм уу, үгээр уясаар байгаад орой болгочихов. Мань над нарийн хоол хийж өгнө гээд хоёрхон шарвин хийлээ, би нэлээд өлсөж явсан болохоор цааш нь хэдийг хийдэг юм бол доо гээд харж суусан чинь нэмэх царайгүй. Тэгээд хэдэн мод зэрэглээд, галлатал тогоо нь дорхиноо халж, жаахан тос хийгээд шарвингаа хайрч гарлаа. Тос нь шарвиндаа шингээд ч юмуу, ширгээд ч юмуу дууслаа, үнэр ч гэж арааны шүлс гоожим. Тэгтэл хоёр шарвингаа нэг паалантай саванд хийгээд, ганц хоёр дусал ус цацаад дарчихлаа. Хэсэг зуур ярилцав. Тэгтэл хоолоо идэх юм болж, би ч яахав ганцыгаа өлөв долов идчихлээ. Мань хүн бараг л махыг нь тоолоод, гурилаас нь чимх чимх авч, удаан гэгч хооллов. Аяга цай хийж авсныхаа дараа “Хүүхээд, чи янз нь цадсангүй дээ, би дахиад шарвин хайрах уу” гэхэд нь би нэрэлхсэндээ болоод “хэрэггүй хэрэггүй” гэв. Гэвч мань эр дахиад нэг шарвин дорхиноо хийгээд мөн л “ид ид” гэлээ. Би өөрийг нь дуурайгаад алгуурхан, сайтар зажилж идвэл нээрээ л цадчих шиг болов. Бид хоёр шөнөжин хуучилсан, дахиад лав өлсөөгүй. Ай даа, лам явсан хүн өтөлсөн хэрнээ зангаа тавьдаггүй юм билээ” (25) хэмээн ярьж байжээ.

Ардын засгийн жилүүдэд, тухайлбал 1930-аад онд Гандантэгчинлин хийдийн лам нарын ахуй байдал яльгүй дээрдэх тийшээ байсан бололтой. 1934-1937 онд тус хийдэд шавьлан сууж байсан, 1999 онд 83 настай байсан, улсын заан Л.Нямжав гуай: “Би Их Хүрээнд ирээд Түмбүүш хэмээх Банзрагч ламтнынд сууж байсан. Хуралд суухад 20 мөнгөний зэд өгнө. Түүнийгээ хадгалж хураана. Тэгэхэд кг мах 70 мөнгө байсан. Бид хоёр зэд, погоороо товхийтэл амьдарч байсан” (26) хэмээн ярьж байж билээ.

Зэрэг зиндаанаасаа үл хамааран, Хүрээ хийдийн лам нарын нийтлэг шинж бол амьдрал ахуйдаа тун арвич хямгач, цэвэрч нямбай, аливаад чанд дэг журамтай хандаж

байсан явдал юм. Төрийн ахмад зүтгэлтэн, Монгол Улсын гавъяат хуульч Ц.Готов, Ардын зураач, төрийн шагналт Н.Жамбаа, Соёлын гавъяат зүтгэлтэн, лам Данзан, улсын заан Л.Нямжав, миний нагац өвөө Б.Ёндон, аав Ц.Жигжид зэрэг хүмүүсийн ярьж байснаас үзэхэд, хүрээ, хийдийн лам нарын гэр, хашаа цэвэр цэмцгэр, бурхан тахил нандин, эд хогшил нь энгийн мөртлөө гял цал, зуух нь хүртэл арчиж зүлгэсээр байгаад нүүр харагдам болсон байдаг байжээ. Түүнчлэн лам хүний хоолны дэглэм нарийн “хязгаартай хооллох” баримтлал бөгөөд гол нь хоолоор бус, ухаанаар буюу тэвчээрээр хооллох дэглэм байсан аж.

Лам нарын их зонхи нь дунд гарын шаазангаар нэг аяга, бүр их бол нэг хагас аяга хоол иддэг, хоолоо яг идэх хэмжээгээрээ илүү ч үгүй, дутуу ч үгүй хийнэ, хоол яг буцалж болоход л таарах 5,10-хан нарийн зомгол, цуудас түлш зарцуулна, цай ч бас л тийм маягаар чанана. Шавь нараа эхнээс нь амьдрал ахуйдаа нягт нямбай ханддаг болгон хүмүүжүүлнэ. Миний эцгийн шавьлан сууж байсан хамаатны ах лам нь гурил элдүүлээд дув дугуй элдэхгүй бол дахин нухуулж элдүүлдэг, модыг муруй хазгай тайрвал дахин тэгшилж хөрөөдүүлдэг, модоо тусгай дэвсгэр дээр хөрөөдөн үртсийг нь хүртэл авч түлдэг нарийн нямбай хүн байсан тухай аав маань дурсан ярьдаг байсан юм. Мөн Ц.Готов гуай: “Би 1930-аад оны эхээр Их Хүрээнд ирж, ээжийнхээ хамаатны ах лам Сундуй гэлэнгийн дүү буусан. Тэр ах маань: “Чи миний гарын ая даахгүй, чамайг хоолтой, ундтай айлд суулгана” гэсэн. Тэр ёсоор сүүлд нь өөр айлд суулгасан. Хэд хоног гэлэн ахтай хамт байснаасаа цухас төдий хөндвөл, ах маань орой дунд гарын шаазангаар ганц аяга хоол иднэ. Хоёр хүнд зориулж, хоёр аяга л хоол хийж байсан. Надад гурил элдэхийг зааж өгөхдөө, ганц хавтгай гурилыг сайтар нухаж, элдээд гэрэл өөд дэлгэн барьж харуулахад маш жигд, нимгэн, цаана нь байгаа зүйл тодрон үзэгдэхээр элдсэн байсан. Ингэж аливаа зүйлд нягт нямбай хандахын үлгэр жишээг үзүүлдэг чамин лам байсан” (27) хэмээн дурсан ярьж байна. Лам хүний арвич хямгач байдлыг арай хэтрүүлсэн юм уу даа гэмээр яриа ч ард олны дунд ам дамжин яригдаж иржээ.

Тухайлбал, нэгэн лам гурил дотроосоо аалз гарч ирэхэд барьж аваад, наалдсан гурилыг хөл бүрээр нь гөвж байсан гэдэг. Лам хүн архи, дарс хэрэглэхийг хатуу цээрлэнэ. Гандантэгчинлэн хийдийн нэгэн гавьж хоёр шавиа айраг ууж, нүүр нь улайж хүрэнтсэн байдалтай ирэхэд: “Та нар яасан задарсан тархинууд вэ? Би 5 жилийн өмнө ноёны найранд очоод ганц хундага архи, хэдэн аяга айраг уусан. Одоо болтол толгойноос гараагүй байна” хэмээн захинач байсан гэдэг.

Улсын заан Л.Нямжав: “1930-аад онд Майдар эргэх үед олон арван залуу лам, банди нарын дунд ууттай 20-тын мөнгө өгөхөд хүн бүр хувиа аваад, эцэст нь ганц ч дутдаггүй байсан” (26) хэмээн хуучилсан юм. Энэ нь залуу лам, банди нарыг бурхны шашны ном ёсны дагуу шуналыг үл тэвчих үзлээр хүмүүжүүлж чадаж байсны нотолгоо бүлгээ.

Өмнөх тогтолцооны үед лам нарын нягт нямбай байдлыг хүмүүжлийн өгөөж, сургамж талаас нь үл тайлбарлан, харамч, нарийн, ховдог, шунахай гэх мэтээр бүхэлд нь ангич байр сууринаас хараар будаж тайлбарлаж байсан юм. Гэтэл эл байдлыг бодитой авч үзвэл нэг талаас ариун винайн ёсыг чанд мөрдөх шашин номын агуулга, нөгөө талаас хүнийг хүний зэрэгтэй явуулах хүмүүн ёсны жудаг сахисан шинж давамгайлж байсныг тэмдэглэн хэлмээр байна.

Энд их төлөв дунд, доорд буюу эгэл лам нарын бүлэгт багтах маарамба, зурхайч, даяанч, бадарчин гэх мэт өвөрмөц бичил бүлгүүдийн тухай цөөн үг хэлье.

Лам эмч буюу маарамбад бага наснаасаа шавь орсон банди нар анагаах ухаанд шимтэн дурлаж сурч, судлаад оточ болдог. Тэд бусад банди нарын нэгэн адил эхэн үедээ төвд бичиг, бурханы ном үзэхийн хамт багшийнхаа барих эмийн ургамал түүх, хатаах, нүдэх, боох ажилд туслаж, эмчилгээ хийх анхны мэдэгдэхүүнтэй болно. Шашны бага сургууль төгсмөгц Манба дацанд элсэн суралцаж оточ болох замдаа орно. Тэд хүн эмчлэх ухааны суралцахын хамт сэтгэл засалд мэргэшинэ. Үнэхээр авъяаслаг зарим нь 20 гаруй

насандаа “жигжигхэн эмч” болж эхэлнэ. Монголын их сэтгэгч Ч.Дэмчигдорж “Оточ хэмээгч хүн, амьтны өвчин зовлонг арилгаж, амьдралыг хамгаалах эрхэм ёсон” (28,98) хэмээн тодорхойлжээ. Бас эмчилгээндээ дом, шившлэг зэрэг монголчуудын эртний уламжлалт сэтгэл заслын аргыг хэрэглэнэ. Үнэхээр нарийн мэргэшсэн олон оточ маарамбууд олон байжээ. Жишээ нь: Түшээт хан аймгийн Дайчин вангийн хошууны Өсгий маарамба хэмээх гайхамшигтай оточ байжээ. Тэрбээр судас барих мэтээр үзэж, үзэж нь их төлөв өсгийд нь нэг ханаад л барагтай өвчнийг эмчилдэг оточ байж. Иймээс Өсгий маарамба хэмээн алдаршсан байна. Энэ алдарт оточийн тухай олон хууч яриа, домог бидэнд уламжлагдан үлджээ. (29,308-309)

Томоохон хүрээ хийдүүдэд **Зурхайн дацан** байсан бөгөөд тэдгээрт “Дүйнхорыг голлох тарнийн аймгийн номлол, сонсол агийн дамжаа Чойрын таван ботийн хэлэлцээн гавьж болон Парчин дамжаа, Жүшийн гарын авлага лугаа сэлттэй анагаах ухааны сургалт, уламжлалт зан үйл Пүг ёсоор Бидэргаравыг голлон судлах хар, цагаан зурхайн гарын авлагууд” бий (30,26) гэжээ. Зарим лам нар залуу багаасаа зурхайн ухаанд голлон суралцаж, “шарсан мах анддаггүй шар зурхайч” болж байсан аж. Зурхай нь тооны ухаанаар жишиж, орчлон нирвааны далд учралыг хязгааргүй гайхамшигтайгаар бодон үзүүлэх оюун ухаан юм. Нэрт сэтгэгч Ч.Дэмчигдорж: “зурхайн хэмээгч тэнгэрийн утга хийгээд цаг улирал ба аливаа мэргэлэх зүйлийн нарийн нууц эрдэм” (28,98) хэмээжээ. Зурхайч нар лам нар монголын нийгмийн бүтцэд тоогоор цөөн боловч оюун ухаанаараа томоохон жин дарж байсан байна. Зурхайчийг энгийн хэллэгээр илэрхийлвэл, төсөөлж ургуулан бодогч, хүний заяа төөргийг зураглаач гэж хэлж болно. Зурхайн чиглэлээр гаарамбын дамжаа амжилттай барьсан лам Зээрэмбийн зэрэг хүртэнэ.

Лам нарын доторхи өвөрмөц давхраа бол даяанч нар юм. Эд нар эгэл лам нарын тоонд багтана. Тэд хүн бараг очдоггүй уулын тагт, агуйд амьдран, бясалгал хийнэ. Энэ тухай академич И.Майский: “...Туул, Орхон голын хооронд орших Дархан ламын хийдэд би хэдэн цаг саатсан юм. Ингэхэд Автономит Монголд жинхэнэ даяанч байдаг: тухайлбал, эл Дархан ламын ойролцоо ууланд ухаж байгуулсан агуй дотор хорвоогоос төгс тусгаарласан хэдэн лам амьдарч байна. Тэд агуйгаас хэзээ ч холддоггүй, амьтан хүнтэй уулзахаас ч зайлсхийдэг, цагийг мацаг барин залбирал үйлдэн өнгөрөөж, хавь ойрын сайн санаатнуудын өргөн барьсан зүйлээр дөнгөж өл залгах ажээ” (6,353) хэмээн тэмдэглэжээ. Ийм лам нарын дийлэнх олонхи Монгол орны эрс тэс уур амьсгалтай нөхцөлд дөрвөн улиралын турш даяанчилж амьдрах боломжгүй байсан байна.

Даяанч лам нар бясалгах, унтах, хооллох талаар маш нарийн дэглэм баримталж, дээд зэргийн тэсвэр тэвчээртэй байж, дотоод нөөц бололцоогоо шавхан маш багаар хооллох, ундаалах дэглэм барьж, гүнцэгээ зооглоод юм уу, шингэн юм уугаад модон тагшаа тусгай бэлтгэсэн чулуун дээр нэг үрээд хойш нь тавина. Аяга нь хоног хоногоор элэгдсээр үмх хоол, балга ус залгуулах төдий болдог байжээ. Хүний хүслэн эдлэх жам ёс, хүсэл тачъяалыг умартана. Гэсэн хэдий ч хүний биологийн хүчин зүйл давамгайлж байдаг гэдгийг доктор С.Пүрэвжав багш: “Нэгэн даяанч лам эзгүй зэлүүд ууланд амьдарч, бясалган, хүний эгэл амьдралыг үндсэнд нь мартжээ. Тэр өдөр нарны элч хүчтэй шарж байсан тул нүцгэн шалдан, толгой халахаас сэргийлж, сийрсэн малгай тавих төдий л байжээ. Гэтэл хаанаас гараад ирсэн юм бүү мэд, хоёр сайхан залуу бүсгүй ламтан руу гэнэт хүрээд иржээ. Тэвдсэн даяанч сийрсэн малгайгаа авч нуудгай дээрээ тавьж амжив. Хоёр бүсгүй даяанч ламаас элдэвийг асууж, бас судсаа бариулжээ. Гэтэл нуудгайгаа дарж тавьсан сийрсэн малгай савлан хөдөлж байсан юм гэнэ лээ” гээд эгдүүтэй аргагүй нуг нуг инээж байсан билээ.

Лам нарын доторхи өвөрмөц бага бүлэг бол бадарчин нар юм. Бадар барих, бадарчлах ёс бол эртний Энэтхэгээс үүсэлтэй (31).

Монгол оронд бурхны шашин гурвантаа дэлгэрсний дараа Төвдийн Лхас хотноо эрдэм номоо гүнзгийрүүлэх, эргэл мөргөл хийх зорилгоор лам нар бадарчлан явах болсон байна. Тэдний их зонхи нь эхэн үедээ бурхны номонд шунасан орь залуу настай, оргилуун

тэмүүлэлтэй, газрын холыг явган туулж, тэсвэр хатуужил, хат суусан номын ав шиг дүүрэн хүртсэн хүмүүс байжээ. Тэд Утай, Гүмбэн, Лхас хотноо очиж, эрдэмтэй ламд шавь орж, шашны шилдэг сургуулийг гүйцээн, чамгүй сайн боловсрол эзэмшээд, нутаг орондоо буцаж ирж, бурхан шашныг түгээж байсан аж. Бадар барих гэж буй лам эрдэм номоо гүнзгийрүүлэхээр алс хол явах гэж байгаагаа хийдийнхээ хамба, гэсгүйд гомбо (чөлөө гуйх утгатай төвд үг) айлтгана. Хийдийн удирдлага бэлтгэлийг нь шалгасны дараа зөвшөөрөл өгөөд, юу, юу голлон сурч ирэхийг зөвлөнө. Чингээд тухайн лам бадар аяга өвөрлөн, хавчиг үүрч, хоёр саваа таяг тулан алсын замд гардаг байжээ. (32)

Нэг бадарчин хавчигтаа 30-40 кг ачаа үүрч, хоногт 20-30 км зам туулна. Эхний өдрүүдэд арай богино зам туулж, дараа дараагийн өдрүүдэд явах замаа сунгана. Хээр унтаж амрахдаа толгойгоо газрын уруу харуулан хөлөө жийж унтана. Энэ нь хөлөө амраах арга юм. Хоногийн газар бүр давстай хар цайгаар биеэ шавшиж, биеэ чийрэгжүүлэн буларч няцрахаас сэргийлнэ. Зуны дэлгэр цагт жодгороо барин хаана ч хамаагүй хононо. Харин өвлийн хүйтэн сэрүүн цагт айлд хоног тааруулна.

XIX зууны сүүлч XX зууны эх гэхэд бадарчдын тоо эрс олширсон байна. Олонхи нь дотооддоо аймаг, хошуу дамжин, цөөн хэсэг нь хилийн чинадад явж бадарчлах болжээ. Сүүлдээ бадарчлах нь хот, хөдөөгийн хооронд хэрэн тэнүүчилж бадар барьж гуйлга гуйж, амь зогоох арга болон хувирсан байна. Гэхдээ бадарчин нар тухайн үеийн монголын нийгэмд дараах үүрэг гүйцэтгэсэн буюу ул мөр үлдээсэн гэж хэлж болохоор байна. Үүнд:

-Бадарчин нараас цөөн тооны хүмүүс Энэтхэг, Төвд, Балба зэрэг оронд очиж билэг эрдмийг гийгүүлэн, нутагтаа буцаж ирж, боловсрол, соёлыг түгээгч болж байсан.

-Дэд бүтэц хөгжөөгүй, холбоо харилцаа муутай нөхцөлд аймаг, хотуудын төдийгүй улс орнуудын хооронд мэдээлэл дамжуулах үүргийг гүйцэтгэж байсан. Ийм учраас “Айлын ховыг авгай хүүхэд, аймгийн ховыг бадарчин зөөнө” гэсэн үг гарчээ.

-Бадарчин нар өвчин зовлон тохиолдсон айлд лам, оточийн үүрэг гүйцэтгэн, тэдэнд өмөг түшиг болж, сэтгэл санааг нь засах, ариусгах, өвчнийг анагаах үүрэг гүйцэтгэж байв.

-XIX-XX зууны эхэн үед бадарчингуудаас овсгоо самбаа, эрдэм чадалтайг нь төрөөс цэрэг, улс төрийн тагнуул туршуул болгон ашиглаж байжээ.

-Зарим бадарчингууд судлаач, шинжээчийн үүрэг гүйцэтгэж, хойч үедээ үнэтэй мэдээ сэлт үлдээжээ. Үүний тод жишээ бол Сэцэн хан аймгийн Мэргэн вангийн хошууны тухай нэрт бадарчин лам “Мэргэн жонь” хэмээх Лувсандорж болой. Тэрбээр бадарчилж явахдаа тухайн газар орныхоо байгаль, цаг уур, хүн зоны ёс заншил, онцлогийг судлаж, нийт 86 булш хиргисүүр малтан шинжилж, зарим нутаг орны эрдэм баялаг, ашигт малтмалын орд, эмийн ургамлын тархац зэргийг өөрийнхөө хэр хэмжээнд тогтоож байжээ.

-Бадарчин нар олон газар явж, янз бүрийн ааш араншинтай хүнтэй уулзаж, найрсаг хандсан нэгэнд нь урам, ухаан нэмж, таагүй хандсанд хэр хэмжээнд нь хариу барьж, ая эв, арга залийн аль алиныг хослуулан хэрэглэж байсан байна. Иймээс ч “бадарчин явсан газар балагтай, батгана суусан газар өттэй” гэсэн үг гарчээ. Тухайлбал, нэг бадарчин хаврын цагт айлд хоног тааруулан очтол гэрийн эзэгтэй мах чанаж, нөхөртөө үхрийн тарган хавирга, хошног, бадарчинд жаахан булчин мах, гэдэс хужирхай төдийхнийг өгчээ. Гэрийн эзэн:

-Бадарчин гуай, явсан нутгаар газрын гарц, мал сүргийн тарга тэвээрэг хир байна гэхэд бадарчин:

-Тарган газраа таны урьдах шиг, туранхай газраа миний урьдах шиг л байх шив дээ гэсэн гэдэг. Ингэж ард олны дотор бадарчины тухай шог хошин явган яриа дэлгэрчээ. Энэ нь хөгжсөөр аман зохиолын бие даасан төрлийг бий болгосон байна.

Монголын хууль цаазны ахмад зүтгэлтэн, эрдэмтэн Б.Содовсүрэн гуай өөрийнхөө дурдатгалд: “Орчлонгийн хүний зам ээдрээтэй, эргэж хурган дурсах зүйл арвин байдаг. Сүм хийдийн лам нар эрдэмгүйгээ “асман” гэж хочилдог цаг байжээ. Бурханы шашин хүмүүсийн ухамсарт давамгайлж эрэгтэй хүүхдээ сахил хүртээж, лам болгох уламжлал тогтсон байв. Боохойноос өөр аюулгүй, байгалийн гамшгаас өөр бэрхшээлгүй, хээр талын

малчны бор гэрт хөл хөдөлгөөнгүй, ээж хүрэн өнгийн эдээр дээл эсгэж, хэрдээ завгүй байсны цаад учрыг гадарласангүй. Бурхандаа зул өргөж, лам захтай шинэ дээл өмсгөн, миний хүү лам болж, ном үзнэ гэх ээжийн үг сонин сонсогдож байлаа. Намайг дагуулж тавагтай идээ барин айлдаа ороход Гарам гэлэн гуай хувцсаа сольж, бурхан тахилаас нь арц хүжийн анхилам үнэр ханхалж байсан санагдана.

Өвгөн ламд хадаг барьж хүүд сахил хүртээж хайрла хэмээн сөхөрч, гэлэн гуайг багш гэдэг юм шүү гэж захив. Багш лам адислаж, шоголтой номноос түвд цагаан толгойн эхний үсэг нүдлүүлснээр бяцхан ёслол өндөрлөж, ухаан сэлбэх гараагаа авч билээ. Тэр цаг үеэ эргэн санавал хонхны дуутай нүд анихыг хүсдэг хөгшчүүлийн хүсэлтэй ээжийн сэтгэл нийцсэн байлгүй. Цагийн эргэлтээр хүйтний ам наашилж, хөхүүрийн ам цаашилж эхэлмэгц Мөхийн жаст багштайгаа шавилахаар бор гэрээс хөндийрөх нь таагүй ч “усыг уувал ёсыг дагадаг” болов. Мөхийн жасын сүм, дуганы бурхан тахил, хурал номын хэрэгсэл балчир насны сонирхол татаж, аливаа шинэ зүйл эхэндээ сонин байдагчлан учрыг олох гэж хичээж, аяндаа дасч эхлэв. Багш лам хурал номын уншлагад дагуулж ороход овоодой өмсөж, орхимж нөмрөн, бор тагш өвөртлөхөө мартдаггүй байв. Жасын хувраг цөөн, чөлөө зөвшөөрөлгүй орох гарах хориотой, зөрчвөл торлог, бэрээний амт үзүүлж, хурлын ёс жаяг сахиулдаг гэсгүй ламтай. Жасын манж, цав хурлын номноос дутуугүй сонирхол татдаг байсансан. Жасын амьдралд түргэн дасаж, үе тэнгийн хүүхдүүдтэй танилцаж, чөлөө заваар тэвэг өшиглөх, хушга харван наадахыг сонирхон, сумын танхимын тухай тэдний мэдэмхийрэн цуурах нь томчуулын яриа байжээ.

Цаг тавьж, цас хайлан, урь унаж хүн малгүй хөдөлгөөнд орж багш ламын “бид хоёр хөдөөлнө” гэж хэлэхийг сонссоноос хойш, цаг өнгөрөхгүй, хоног тоолон гэртээ харих хүсэлд хөтлөгдсөн юм. Нойр хулжин, бор гэр хайрт ээж хонь хурга дүрслэгдэн, унаа хэлүүлснээр сэтгэл амарч гэрийн зүг хөдлөхдөө хөл хөнгөрөв. Тэр жилийн хавар салхи шуурга ховор, ногоо эрт соёолж, сүү тараг элбэгшиж, хүн малгүй тэнэгэр, санаа сэтгэл тайвшран байгаль ээж хишгээ хүртээж байжээ. Хонь хурганы хуучин даамалд хуврагийн хувцас зохихгүй гэж хувцсаа сольж, нутаг усны бор толгодоос Мөхийн Жасын барааг харахдаа буцаж очихгүй гэдгээ мэдсэнгүй.

Цагийн аяс дагаж лам болсон ч цаана нь гэрэл гэгээтэй өөр зам угтаж байсан юмсанжээ.” (33,8,9) дурсан бичжээ.

Энэхүү дурдатгалд гарч буй лам нарын “хөдөөлөх” гэдэг хаврын урь орж, яргуй дэлгэрэх үеэр хот хүрээний чийг бамаас холдож, шавь нарынхаа эцэг, эхийнд юм уу, хөдөө ах дүү төрөл төрөгсдийнхөө гэрт очиж, зочлуулан хүндлүүлж, ном гүрэм уншиж бясалгал хийхийг хэлнэ. Сайн ноён аймгийн Эрдэнэ бандид хутагтын (Ламын гэгээний) хүрээний болон Түшээт хан аймгийн Түшээт засаг гүн Доржболдын зохиосон жаяг зэрэг дотоод дүрмүүдэд: “...шавь нар хөдөө гарахын зөвшөөрлийг хамба, шун-уй гэсгүй, литуслах гэсгүй, дацан гэсгүй нарт айлтгах хэрэгтэй бөгөөд цай, хадаг сэлттэй айлтгана, цай, хадаг муу болбоос цаазална, гадагш одох хоногийн тоог лам ли нар мэдэж өг, тэдгээрт (чөлөө авсан лам нар зэд өгч болохгүй, хөдөөлөхийн зөвшөөрөлгүй явбаас хатуу цаазална), шинэ суугчид (шинээр лам бологсод) гурван жил болоогүй хөдөөлөх зөвшөөрөл айлтгаж болохгүй, айлтгаваас шун-уй хатуугаар цаазалж, хийдээс хөөнө” (34) “Нэг өдөр хуралдаж дутваас 100 мөргүүл, хоёр өдөр хуралд дутваас 150 мөргүүл, гурван өдөр дутваас 100 мөргүүл, 50 зул өргүүл, дөрвөн өдрийн хурал дутваас 150 мөргүүл, 100 зул өргүүл” (35) гэх зэргээр хурлаас чөлөөлөгдөх, хөдөөлөх, түүнийг зөрчвөл хэрхэхийг нарийн зааж өгчээ.

Лам нарын их зонхийн үлгэр жишээч амьдрал, бурханы номын ид шидийн хүчээр сүсэгтэн олон гүн итгэл бишрэлтэй болж, ахуй амьдралдаа чин шударгууг эрхэмлэх болсон байна. 1921 оны хувьсгалын өмнөхөн үеэс энэ тухайд ганц, нэг жишээ татъя. Одоогийн Хэнтий аймагт “Тарган лам” хэмээн алдаршсан ахимаг насны баян хувраг байжээ. Түүний мал сүргийг Хэнтий нутгийнхан төдийгүй, одоогийн Дорноговь, Дундговь, Төв аймгийнхан маллаж байсан гэнэ. Тарган лам нэг дагуул хиатайгаа Эрдэнэ

бандид хутагт буюу Ламын гэгээний хүрээ орчихоод буцаж явжээ. Ихэд өлсөж ядарч яваад эдүгээгийн Дундговь аймгийн нутагт нэгэн томоохон хонхор дүүрэн хоньтой айлд буужээ. Тарган лам:

-Бид холоос явна. Өлсөж ядарч явна, ганц хонь гаргаж өгөөч, үнэ өртөгийг нь өгье гэхэд гэрийн эзэн:

-Би мэдэхгүй. Энэ хүний хонь мал, бид адуулж маллаж байгаа юм гэхэд тарган лам:

-Хэний мал сүрэг юм бэ? гэж асуухад гэрийн эзэгтэй:

-Энэ тарган лам хэмээх буянтай хүний мал байгаа юм. Хэдэн жилийн өмнө тарган ламын сүргийн даамал 300 хонь авчирч өгөөд, тэр ламтанд биднийг эчнээ шавь оруулсан. Тэр цагаас хойш 4,5 жил өнгөрлөө. Хонь нь мянга гараад байна. Манайх сааль, шимийг нь ашиглаж, эргүү, догол мэтийн өвчин тусах маягтайг нь идэшинд хэрэглээд буянтны буянд болж л байна. Сүргийн даамал жилд нэг удаа ирж малаа тоолоод ноос үсийг нь аваад явдаг юм гэж ярьжээ. Тарган лам:

-Төөрсөөр төрөлдөө гэгчээр юм бол. Тэр тарган лам чинь би байна гэхэд эр, эм хоёр нэлээд гайхаж тээнэгэлзэж, бас сүсэглэх байдалтай байснаа:

-Таныг бид тарган ламтан гэж юугаар нь мэдэж итгэх юм бэ? гэснээ хоёул гарч шивнэлдэж байгаад орж ирэн:

-Бидний багш-тарган ламтан мөн эсэхийг бид мэдэхгүй байна. Харсаар байтал холыг зорьж, ядарч яваа ахмад тохитой хүн байна. Нэг төлөг эргүүтэх маягтай, овоо тарган төлөг байгаа юм, түүнийг төхөөрч, танд шөл уулгая гэжээ. Тарган лам, түүний дагуул хоёр ч хонины шинэ мах идэж, шөл уун овоо тэнхэрчээ. Тарган лам:

-Та хоёр үнэхээр бурхан ном, багшдаа үнэнч, чин зүтгэлтэй шавь нар байна. Миний мал хөрөнгийг өөрийн мэт хайрлаж, хамгаалж байдаг юм байна. Намар манайд яваад очоорой. Та нарын бишрэл, чин зүтгэлийг би үнэлэх болно гээд яваад өгчээ. Гэвч тэднийх чөдрийн ганц морьтой тул тарган ламынд зорьж очиж чадсангүй. Ламтан ч байдлыг ойлгосон бололтой, сүргийн даамлаараа унааны хоёр морь, хариулж буй хониноос нь зууг тэдний өмч болгон таслаж өгч байгаагаа батламжилсан бичиг шийтгэн явуулсан байжээ.

(36)

Жасын кампанийн үед (1930 он) сүм хийдүүд сүсэгтэн олон шавь нараараа мал хариулуулсны шан хөлсөнд бойжуулсан төлийнх нь зохих хувийг урамшил болгон өгдөг журамтай байжээ. Гэтэл жасын мал хариулагчдын их зонхи нь эхэн үедээ харьяат жасдаа бойжуулсан бүх төл малаа нэгд нэгэнгүй бүртгүүлж, өөртөө үлдээлгүй өгдөг байсан аж. Тэд тэрхүү малыг бурхны өмч, багш лам, ариун санваартны хөрөнгөнөөс авбал хоол болохгүй, нүгэл гэж “Жасын малаар баян болохгүй, жалгын үгээр цэцэн болохгүй” гээд огт халгаахгүй байсан гэдэг.

Лам нарын ихэнхи хэсэгт ч хүний төлөө гэсэн сэтгэл, юухан хээхнээр ч болов уу хүнд тус хүргэхсэнсэн чин санаа байсныг олон жишээгээр хэлж болно.

Говийн нэгэн худаг дээр ламтан худгаас ус татаж, мал услаж байтал танихгүй хүн ирж морио услаад явахдаа чөдрөө орхичихоод явчихжээ. Нөгөө лам: “Ойрын хүн бол заавал буцаж ирж чөдрөө авна, чөдрийг нь энд орхичихвол хүн аваад явчихна, би аваад гэртээ харьвал нөгөө хүн ирж цаг алдаж хөөрхий болно” гээд өглөөнөөс орой хүртэл гурван өдөр худаг дээр өнжин хүлээж байсан тухай ахмад сэтгүүлч Л.Хайдав гуай хуучилсан юм. (37)

1921 оны хувьсгалын өмнө лам нар нийт хүн амын дөрөвний нэг хувь, материаллаг үйлдвэрлэлийн гол хүч эрэгтэйчүүдийн 40 шахам хувийг эзэлж байсан нь үйлдвэрлэх хүчний хөгжил, хүн амын нөхөн үржихүүд сөрөг нөлөө үзүүлж байжээ. Лам хуврагууд ард олны сэтгэл санааг ариусгах, соёлын хөгжлийг урагшлуулахад эерэг нөлөө үзүүлж байсан боловч бурхны номыг гол төлөв төвд хэлээр урьж байсан нь жирийн олонд үл ойлгогдон, мухар сүсэгт автахад хүргэж байсан байна. Мухар сүсэг нь сүсэгтэн олны чөлөөт сэтгэлгээ, бүтээлч арга бариллыг хаан боогдуулж байсан нь ойлгомжтой. Лам нарыг гэрлэхийг хориглон, хүний хүслийг эдлэх боломжийг хааж байсан нь хүн амын нөхөн

I. МОНГОЛЫН ТҮҮХИЙН ДУНДАД ҮЕИЙН АСУУДАЛ

үржихүй, нөхөн үржихүйн эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж, зарим гаж үзэгдэл дэлгэрэхэд хүргэсэн байна. Зарим лам нар шавьтайгаа, банди нар хоорондоо “бандидах”, “хасдах” зэрэг ижил хүйстэнтэй явалдах бусармаг явдал багагүй байсан аж. Лам нар тухайн хүрээ хийдийн гортигоос гармагц харчуулын хороолол руу гүйж, эмс охидтой орооцолдох болсон байна.

Энэхүү илтгэлд нь цаг хугацааны багтаамжаас болж, сүм хийд, лам нарын асуудлыг Монгол оронд хэрхэн шийдвэрлэсэн гунигт түүхийн тухай өгүүлэх боломж байсангүй, зөвхөн монгол хуврагийн амьдралын ерөнхий төрх төлөвийг авч үзлээ. Харин Коминтернээс Монголд ажиллаж байсан төлөөлөгчид, манайд ирж, очиж байсан ажилтнууд, түүнчлэн 1931 оны X-XI сард Монголд ажилласан ЗСБНХУ-ын ШУА-ийн экспедицийн материалд тулгуурлан, Г.Кара-Мурзагийн хийсэн дүгнэлт, гаргалгаа зэрэг нь И.В.Сталин, түүний гар хөл бологчдыг лам нарын эсрэг довтлох, хайр найргүй хандах өширхөл, сэтгэл зүйг төлөвшүүлж өгчээ. (38)

Abstract

This narrative examines the lifestyle of Mongolian monks during the late 19th to early 20th century. Monks were classified into higher, middle and lower ranks, and their livelihood were demonstrated. It also studies special micro groups of monks such as maaramba monk, zurhaich monk, dayaanch monk and badarchin monk. Consequently it concludes that monks were covering the main roles and responsibilities in the society, and leading exemplary lifestyle of that certain time period.

Зүүлт, тайлбар

1. Лам нар нь түвдийн теологийн нууцад нэвтрэхийг эрмэлзэн суралцахын зэрэгцээгээр ламын сахил хүртэнэ. Түүнд дөрвөн зүйл багтаж орно. Нэгд, хамгийн хөнгөн сахил /"гинин"/ хүртсэн хүн том нүглийг цээрлэнэ: хүн алахгүй, хулгай хийхгүй, архидаж согтуурахгүй гэх мэт. Энэ сахилыг голдуу хөвгүүд хийдэд ирж суухдаа амлан андгайлна. Энэхүү “гинин” хэмээх сахилыг энгийн хүмүүс ч хүртэж болно. Хоёрт, Нэлээд чанга сахил /"рабджен"/ бөгөөд үүнийг сахихад бэлгийн хавьтлыг тэвчихийн хамт бурхны номын хуралд оролцох эрхтэй болно. Энэ хоёр дахь сахилыг лам нар бурхны номлолын доод шатны сургуульд байхаасаа хүртэнэ. Гуравт, “Гэцэл” энэ сахил бол ямагт ганц үнэнийг ярьж байхыг андгайлсан сахил бөгөөд түүнийг лам нар сургуулийн доод шатнаас дунд шатанд шилжихдээ, өөрөөр хэлбэл ойролцоогоор 15 орчим настай байхдаа хүртэнэ. Дөрөв, Энэ бол “Гэлэн” хэмээх, ламын бүрэн төгс чанар бүрдэж эхэлсэн үеийн сахил бөгөөд үүнийг хүртсэн хүн 250 гаруй янзын зүйлийг тэвчих учиртай /тансаглахыг тэвчих, хоол ундаа тааруулж хэрэглэх, шөнийн нойроо 3-4 цаг хүртэл багасгах гэх мэт/. Энэ дөрөв дэх сахилыг лам хүн дунд шатны дамжаа дүүргэхдээ, өөрөөр хэлбэл, барагцаалбал 25 насандаа хүртэнэ. Дөрөв дэх бөгөөд сүүлчийн сахил хүртэх лам хүн ламын ёсны сахилга алдан, архидан согтуурах, авгай хүүхэн эргүүлэх гэх мэт зөрчил гаргахад хийдийн захиргаа мэдээгүй юм шиг өнгөрөх нь буй. Харин “гэлэн” сахил хүртсэний дараа иймэрхүү буруу явдал гаргавал хатуу шийтгэнэ: буруутан лам хийдийн шүүхэд шилжинэ, зохих тооны бэрээдэх, суран ташуураар ороолгох, бүтэн хагасаас хоёр сар хүртэл хугацаагаар хийдээс хөөх зэргээр шийтгэнэ. Хийдээс хөөгдөж байсан лам дөрөв дэх сахилыг шинээр дахин хүртэх боломжтой. Гэхдээ энэ хатуу чанга арга хэмжээ ч тэр болгон санасан үр дүнд хүрдэггүй байжээ.

2. Ладислаус Формат. “Өргөө дэх цуст хядлага” (Иозеф Гелетагийн өдрийн тэмдэглэлээр бичжээ”. УБ.1992.)

3. Ч.Жүгдэр. Монголын нийгэм-улс төр, философийн сэтгэлгээний хөгжил. УБ.2006.

4. Дом тавина гэдэг нь маргаж, талцаж, сурсан ном эрдмээ уралдуулан ухаанаа сорьж, шалгуулж буй хэрэг юм. Томоохон сүм хийдүүдэд дом тавихдаа Хүрээний гортигоос гадуур дэнж дэвсэг газар хийдэг байжээ. Жишээ нь: Дайчин вангийн хүрээнийхэн зүүн хойт талын дэвсэгт дом тавьдаг байсан аж. Одоо хүртэл Булган хотын зүүн талд байдаг дэвсгийг Домын дэвсэг хэмээдэг.

5. Ж.Болдбаатар. “Өгөөж баян Бугат нутаг мину” УБ.2004.

6. И.М.Майский. Орчин үеийн Монгол (Автономит Монголын шашны амьдрал) УБ.2001.

7. 2008 оны II сарын 1-нд ээжтэйгээ (Л.Санжаасүрэн) ярьсан яриа. Хувийн архив.

8. Миний нагац өвөө Б.Ёндон гавьж насан өөд болохын өмнө: “Манай удамд энэ хөөргийг таван үе номтой хүн барьсан юм. Болдбаатар энэ хөөргийг өвлөх ёстой зургаадахь хүн хэмээн улаан дэвсгэртэй хөх луу ороосон шаазан хөөрөг өгсөн билээ. Бүр 1970-аад онд Булган аймгийн харъяат өндөр настан Банзрагч,

I. МОНГОЛЫН ТҮҮХИЙН ДУНДАД ҮЕИЙН АСУУДАЛ

Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сумын харъяат, Дампил гавьж гуай нартай тамхилахад өвөөгийн хөөргийг таньж, маш олон хүн гавьжийн дамжаа барихдаа энэ хөөргийг гуйн барьж тамхилдаг байсан, их эрдэмтэн лам нарын гараар орсон хөөрөг дөө гэж ярьж байж билээ.

9.Журнал. “Жизнь Бурятии”. 1924 №2-3.

10.МАХН-ын шашин шүтлэгийн тухай гол бодлого ба товч тогтоол. УБ.Орос-Монгол хэвлэлийн хороо. 1925.

11.БНМАУ-ын түүх. 3 боть зохиол. Дэд дэвтэр. (1604-1917). УБ.1968.

12.РГАСПИ. (Российский государственный архив социально-политической истории) Ф.495 ОП.152.д.143.

13.ШУА-тийн Түүхийн хүрээлэнгийн гар бичмэлийн сан (1008 дугаар хэрэг)

14.Зарлигаар тогтоосон Монгол улсын хууль зүйлийн бичиг. УБ.1995.

15.Ж.Болдбаатар, Ц.Пүрэвсүрэн. Халхын толгой баяны нэг Сүрэн гавьж. МУИС.НШУС. Түүх V. Эрдэм шинжилгээний бичиг. №262 (33)

16.Арьяабол бол буддийн аврагч бурхан бөгөөд Шагж-Мүүний хувилсан олон дүрээс үлэмжийн их шүтэгддэг нь юм. Буддагийн домогт гардгаар: Арьяабол Сүмбэр уулсын оройд гарч дуулим ертөнцийг бүхэлд нь эргэн тойрон харжээ. Тэрбээр баруун зүгт харахад нь тоо томшгүй их гай зовлон мэлмийд нь туссан байна. Тэгэхэд баруун мэлмийнээс нь цоргим халуун нулимс газар дээр дусчээ. Тэрбээр зүүн зүгт харахад нь мөн л тоо томшгүй их гай зовлон мэлмийд нь тусчээ. Тэгэхэд түүний зүүн мэлмийгээс цоргим халуун нулимс газар дээр дусчээ. Тэрбээр ертөнцийг хараад хэн хүнд байхгүй их өрөвдөх сэтгэл төржээ. Арьяабол хүний нүглийг наминчлахын тулд өөрийгөө золиослохоор шийдэн толгойгоороо хад мөргөж арван хэсэг болж задарчээ. Гэвч их Будда Арьяаболыг дахин амилуулж толгойны нь задарсан хэсэг болгоныг амьд толгой болгон хувиргажээ. Тэгээд Арьяаболын амилсан арван толгойны дээгүүр Буддагийн өөрийн нь арван нэгдэх толгой туяаран гэрэлтжээ. Гандан хийдэд Арьяаболын сүм байсан.

17.С.Пүрэвжав. Хувьсгалын өмнөх их Хүрээ. УБ.1961.

18.Өглөгийн эздээс сүм хийдэд өргөсөн зүйлийг нийт лам нарт хуваариалан олгохыг ээд хэмээнэ. (Түвдээр түгэл гэнэ)

19.Пог-түвдээр өгөх буюу өглөг гэсэн утгатай үг. Тухайлбал, сүм хийдээс лам нарт үе үе олгодог бага хэмжээний мөнгө ба эд барааны зүйлийг ийн нэрлэнэ.

20.Албан тушаал, зэрэг дэв, мяндагаараа нэмэгдэл авахыг “намшиг” гэнэ.

21.С.Пүрэвжав, Д.Дашжамц. БНМАУ-д сүм хийд, лам нарын асуудлыг шийдвэрлэсэн нь. (1921-1940 он). УБ.1965.

22.С.Гомбожав гавьжтай 1958 оны I сарын 31-нд С.Пүрэвжав багшийн ярилцсан тэмдэглэлээс.

23. Доктор С.Пүрэвжав багшийн 1960 оны IX сарын 20-нд лам асан Санжаатай ярилцсан тэмдэглэлээс.

24.Доктор С.Пүрэвжав багшийн 1960 оны IX сарын 20-нд Тунсагтай ярилцсан тэмдэглэлээс.

25.Доктор Х.Гүндсамбуу 1278 онд Доржнямынд төл бойжуулах ажлаар 50 хоноход ийнхүү хуучилж байжээ.

26.Улсын заан Л.Нямжавтай 1999 оны X сарын 17-ний өдөр ярилцсан ярианы тэмдэглэл.

27.1999 оны X сарын 15-ны өдөр Монгол төрийн ахмад зүтгэлтэн Ц.Готов гуайтай ярилцсан ярианы тэмдэглэл.

28.Ч.Дэмчигдорж. Эрдэнэт толь хэмээх шаштир оршивой. УБ.1995.

29.Ж.Болдбаатар, Ц.Пүрэвсүрэн “Булган аймгийн бага нэвтэрхий толь”.УБ.2008.

30.Агваанчүлтэмжамц “Аврал итгэлт Богд Жавзундамбын хийд Баруун хүрээний гарсан ёсыг товч өгүүлсэн шударга оршигчдын чихний чимэг хэмээх оршвой” УБ.1995.

31.Бурханы шашныг үндэслэгч Сидтхарта анх “бадар” аяга (Parta) барин явж, номын авшиг хүртсэн тэр цагаас хойш түүний шавь нар энэхүү бадар аягыг ихэд эрхэмлэх болсон байна. Эртний Энэтхэгийн азар (бадарчин)-ууд буддагийн сургаалийг түгээхээр умрыг зорих болжээ. Ийнхүү азарууд бадар аягаа барин явж, өглөгийн эздээс өглөг хандив хүсэн явсаар бадар барих ёсыг уламжлан хөгжүүлжээ. Ингэснээр бадар барих, бадарчилах ёс дэлгэрчээ. XV зуунд Богд Зонхуба (Лувсандагва) эртний Энэтхэгт анх дэлгэрээд мартагдахад хүрээд байсан “виная” ёсыг сэргээн шар малгай өмсөн, гэлүмбагийн урсгалыг үндэслэсэн юм. Тэрээр өөрийнхөө шавь нарт номт дээлийг өмсгөн, бадар аяга хадгалуулан үдийн идээг цээрлүүлэн виная ёсыг мөрдүүлэх болжээ. Шавь нар нь яндаг (хавчиг үүрэг) үүрч бадар барих болжээ. Ингэж анх бурхны шашинт орнуудын дунд бадар баригч буюу бадарчид үүсжээ.

32.Бадарчин дараах эд хэрэгслийг биедээ авч явж байсан. Үүнд:

1. Хавчиг үүрэг: Хэнгэрэгний томхон бүрээс шиг ширсэн буюу гадарласан эсгий хийцийн дугуй хэлбэрийн тойргийн бургасан тэлэгч бүхий хэрэглэгдэхүүн агуулах сав нэг.
2. Өвлийн зуны сэлгээ хувцас цамц, өмд, дээл тус бүр нэг.
3. Усны сав 5 литрийн дашмаг нэг.
4. Цув хүрэм нэг.
5. Даавуун жодгор майхан нэг.

I. МОНГОЛЫН ТҮҮХИЙН ДУНДАД ҮЕИЙН АСУУДАЛ

6. Нүдсэн цай, давс (ууттай) хоёр
 7. Жижиг тогоо (тагтай) нэг
 8. Аргал түлшний уут нэг
 9. Нүдсэн борц уут буюу үхрийн давсагтай нэг
 10. Арвайн гурил ууттай нэг.
 11. Шар тос олгойны мухар нэг.
 12. Цагаан тос гүзээний булан нэг.
 13. Хоол цайны халбага нэг.
 14. Буян залбирлын том тарни мэрэг төлөг сан судар өврийн ном баринтагтай нэг.
 15. Дэвсгэрийн элдсэн хонь, ямааны арьс нэг
 16. Хоол унд идэх өврийн модон тагш нэг зэрэг.
- 33.Б.Содовсүрэн. Говийн хүү, хангайн охин. (Дурсамж, сургамж). УБ.1996.
- 34.Тагнуулын ерөнхий газрын архив. Өвөрхангай аймгийн Баянзүрх суман дахь Ламын гэгээний хийдийн жаяг, бичмэл эх. Шашин хөөрөг.
- 35.Халхын засаг Доржболдын зохиосон жаяг. Бичмэл эх. УННС.
- 36.2008 онд зохиолч Баасанжавтай хөөрөлдсөн тэмдэглэл. Зохиогчийн хувийн архив.
- 37.Ахмад сэтгүүлч Л.Хайдавтай 2009 оны IV сарын 30-нд хийсэн хөөрөлдөөн. Зохиогчийн хувийн архив.
- 38.РГАСПИ. Ф.495.ОП.152.Д.54.с.1-17, Ф.495.ОП.152.Д.143.с.168.Ф.495.ОП.52.Д.144.с.1-30 зэрэг.